

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Рагчаа	Дугаар	L279
Оршин суугаа аймаг	Хөвсгөл аймаг	Оршин суугаа сум	Эрдэнэбулган
Төрсөн газар	Эрдэнэбулган сум	Төрсөн он	
Ажил мэргэжил	Өндөрнастан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Даян дээрхийн хүрээ	Сүм хийдийн дугаар	ХӨЭБ 053
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 6-р сарын 19	Ярилцлага авсан хүн	Д .Мөнхбат

Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумын Даян дээрхийн хүрээ

Мөнхбат: За бид нар өнөөдөр Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сум, Цагаан-Үүр сумын нутгийн хилийн дээс зааг залгаа газар нутаг болох Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сумын төвөөс зүүн тийш гучин найман км орчим газар, Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумын төвөөс дал орчим км зайд байх Монголын шашны түүхэнд онцгой байр суурийг эзэлдэг эртний түүхт Даяндээрхийн хүрээний туурин дээр шинээр сэргээгдэн боссон даян дээрхийн хүрээний цогчин дуганы гаднах орчноос судалгааны ажлаа үргэлжлүүлж байна аа. Ингээд энэ Даяндээрхийн хүрээний үүх түүх, гарал үүсэл, за шашны мандан бадралынхаа үед ямар ямар одоо сүм дуган дацангуудтай байсан, хэд орчим лам нар шавилж суудаг байсан, ямар ямар уншлагуудыг голдуу хийж явуулдаг байсан, за мөн шашны зан үйлийн бусад ямар үйл ажиллагаа эрхэлж энэ бүс нутгийн сүсэгтэн олондоо үйлчилж байсан энэ тухай ярилцлага хийхээр тус шинээр сэргээгдсэн Даяндээрхийн хүрээний одоо гол цогчин дуганы сахиул өндөр настан Рагчаа гуайтай ингээд ярилцлага хийхээр бэлэн болж байна. Тэгэхээр танаас дараах хэдэн асуултыг асууж энэ хүрээний үүх түүхээс тодруулъя. Тэгэхээр та одоо бага насандаа энэ хүрээнд тодорхой хугацаанд шавилан сууж энэ хүрээний одоо сүм дуган, лам мяндагтнууд за энэ хүрээний бурхан номынхоо үйл ажиллагааг хэрхэн явуулж байсан тухай, нүдээр үзэж байсан имй тэр үеийн хүмүүсээс үлдсэн цөөхөн хүмүүсийн нэг нь ингээд өнөөдөр ч гэсэн хүрээнийхээ бүүр туурийг сахиад сууж байна аа. Тэгэхээр одоо эрдэмтэн багш нараасаа, одоо өвөг дээдсээсээ, ахмад үеэсээ сонсож мэдсэн, одоо таны ой тоонд үлдсэн одоо энэ хүрээний гарал үүсэл үүх түүхээс нь хуучилж өгнө үү?

Рагчаа: За би долоон настай энд Мэргэн хамба багшид шавь орж тэгээд яахав энэ тэр цагаасаа хойш арван гурав хүртлээ энэ шашин сүмийнхээ хажуугаар эргэлдэж энд эргэж мөргөж ингэж байсан хүн. За би болвол тэр ном заалгаж энээ тэрээ болж яаж байсан юм бол байхгүй. Зүгээр ер нь намайг бага балчир настай байхад ингээд татан бүүгдчихсан, ийм л юм. Энэ хугацаанд яахав жаран есөн жилийн хойно чинь одоо энэ сүм дуган

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

нэг хүн одоо хувийнхаа зүгээс мөнгө төгрөг цуглуулж, гадаадын иргэн энэ дуган сүмийг бариулж энэ түүхийн энэ том сүмийг босгож өгөөд, ингээд надад одоо та энийг сахиул хийгээд ингээд байж бай гэж Гандан хийдээс надад одоо ингэсэн юм байгаа юм.Тэгээд би есөн сарын нэгэнд хүлээж аваад одоо энэ нохой жилийн есөн сарын нэгэнд аваад гахай жил болтол одоо ингээд энд сууж байна.Тэгээд энэ хугацаанд эргэлчин мөргөлчин маш их хүн ирж байна.За Гандан хийдээс удирдаад хурал ном ч их хурж байна.Иймэрхүү л маягтай байна даа. Ер нь миний бодож байгаагаар бол энэ энийг тохижуулахад нэлээн хөрөнгө мөнгө хэрэгтэй байсан байх, манай улсаас бол.Тэгээд энэ нь тийм юм хэрэглээгүй, гадаадын хөрөнгө оруулалт ч аваагүй.Одоо сайн санаат гадаад, дотоодын хүмүүсүүд өөрсдөөсөө хувиасаа хувиараа мөнгө цуглуулаад энэ шашин сүмийг одоо унаган төрхөнд нь оруулах ийм зорилт тавиад л ажиллаж байгаа. Энд одоо хөрөнгө мөнгө оруулаж яасан тэр Америкийн эмэгтэй Веце гэдэг тэр энэ талаар одоо явж, өөрөө биеэрээ яваад л энэ харъяалах харъяалах сүм энэ зургаан харуулын нутгаар нь яваад, удирдах хүмүүстэй нь уулзаад ингээд энэ сүмийг босгосон юм.Одоо ч гэсэн мөн нэлээн хэдэн тохижуулахад нь мөн хэдэн төгрөг дахиж одоо өгнө гэж энэ жил хүрч ирээд тэгээд явсан байгаа юм аа.

Мөнхбат: Тэгэхээр монголчуудын язгуурын анхны шашин их монгол улс байгуулагдахаас өмнө төв Азийн нутагт бий болсон.Тэгээд 1206 онд Чингис хаан Их монгол улсыг байгуулаад төрийн шашны хэмжээн өргөмжлөгдөж байсан шашин бол бөөгийн шашин.Тэгэхээр Даяндээрхийн хүрээний үүх түүх бол одоо бөөгийн шашинтай салшгүй холбоотой.Өөрөөр хэлбэл Даяндээрхийн хүрээ бол 13-17-р зууныг хүртэл буюу монголын дундад зууны түүхэн үед үндсэндээ монголын бөө мөргөлийн хамгийн том төв нь байжээ гэж түүхэнд үздэг.Тэгэхээр хоёулаа энэ яриаг түр орхиод яг одоо тэр Даяндээрхийн хүрээний үйл ажиллагаа гэлэгваагийн ёсонд орсон тухай тэр цагаас эхлэж, одоо өөрөөр хэлбэл өнөөдрийн шарын шашин тийм ээ, үйл ажиллагаа нь орсон тэр үеийн түүхээс эхэлж таниас зарим асуултыг асууя.Тэгэхээр зарим түүхэнд одоо түүхчид ном судартаа бичсэнээр бол өнөөдөр одоо үндсэндээ түүхийн шинжлэх ухаанд нэг тоо явж байгаа.1864 онд одоо анхны цогчин дуганыг барьжээ гэсэн нэг ийм баримт байдаг юм байна.Энэ бүр одоо барьсан тухай асуудал бол одоогийн Хөвсгөл аймгийн Рашаант сумын нутагт байсан одоо Рашаантын хүрээ гэж алдартай, Мэргэн вангийн хошууны тийм ээ. Тэр Мэргэн вангийн хошууны Рашаантын хийдийн цорж лам одоо энд ирж тахилга дуудлагыг нь бөөгийн шашныхаас Гэлэгваагийн шашинд буюу шарын шашинд шилжүүлж утга найруулгыг нь өөрчилж ингэж одоо гэлэгваагийн шашинд шилжих явц ингэж өөрчлөгдсөн гэж ярьдаг юм.Энэ одоо 1864 он, энэ анхны цогчин дуган баригдсан гэсэн энэ тоо ер нь хэр үндэслэлтэй тоо байдаг юм бол, танд одоо энэ талар мэдэж дуулсан юм юу байна?

Рагчаа: Энийг болвол мэдэх юм байхгүй ээ, би тэрийг болвол.Харин Даравбандид гэгээний хийд гэж байлаа шүү дээ.Тэндээс удирдлагатай энэ чинь, тэндээс одоо тэр хүрч ирж энэ зохион байгуулаж дуган сүмийг бариулдсан гэдэг.Сүүлийн үед ч гэсэн энд хамба энэ тэр солигдоход Бандид гэгээний хийдээс хүрч ирж одоо хүн томилож байсан.Ийм л учиртай юм.Энэ Мэргэн хамба багш гэж одоо тэр Завхан аймгаас гаралтай хүн.Тэрийг тэр Бандид гэгээний хийдээс өндөр юу, өө харал...өвгөн хамба багшийг өөд болоход тэндээс л хүрч ирээд одоо хүрч ирж

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

үзээд л , тэгээд л одоо эргэж очиж тэр сүүлчийн хамба багшийг, Мэргэн хамба багшийг ирж томилж суулгаж байсан.Тэгээд л тэр үеэс л одоо шашин сүм бүүгаад л тэгээд тэр багш маань ч баригдаад явсан юм.Тэгээд харин тэр сүүлийн үед тэр Хар далайн тэнд байж байгаад бидэнд, энэ ах дүү нартаа захиа зангаа өгөөд ирж уулзах хүн байвал үүлз гэсэн.Тэгээд очиж уулзаж чадах хүн ч байгаагүй байх аа.Тэгээд л тэндээ таалал төгссөн байх даа.Ийм л учиртай юм.

Мөнхбат: Тэгэхээр Даяндээрхийн хүрээний түүхээс үзээд ингээд түүх баримтаас үзээд, хүмүүсийн яриаг сонсож байхад бол одоо яг тэр жил сарынхаа дүйчэн өдрөөр болдог байсан онцлог тэр хурлуудад энэ хавийн одоо салбар хүрээ, өөрийн одоо Дархинтын хүрээ, Уйлганы хурал, Цагааны хурал зэрэг энэ хурал дацангуудаас лам нараа дуудаж авчраад энд хурахад нэг мянга гаруй лам хурдаг, тийм. За нэг ийм тоо байдаг юм.За бүр хэлмэгдүүлэлтийн 1936,1937 оны тэр цөвүүн цаг дор энд үндсэндээ нэг зуу гаруй аграмба гавж, мяндагтнууд за бас нэг хоёр зуу гаруй лам хуварга байсан тухай одоо түүхэнд байж байдаг юм.Энд одоо ер нь та одоо түүхэн тэр одоо сүүлчийнх нь он цагуудыг мэдэж байгаа хүний хувьд энэ хэр бодитой тоо вэ?

Рагчаа: Тэрийг болвол одоо үнэн байх аа.Тэр чинь одоо тийм, яахав залуу бага насныхаа лам нарыг хувь тасалж өгөөд сангаасаа, тэгээд хар болгоод гаргачихсан. За тэгээд дандаа мяндаг тушаалтай, гэлэнгээс л гавж аграмба одоо ийм улсууд нь л эндээ хүрээ хийдээ сахиж байж байгаад л, тэгээд л эндээ одоо төгсгөл болсон юм даа, баригдаж.

Мөнхбат: Даяндээрхийн хүрээний одоо бүрэлдэхүүнд орж байсан ямар ямар дацангууд одоо байж байв?

Рагчаа: За энд бол цогчин сүм байсан, чойрын сүм байсан.Дарь эхийн сүм байсан. Жүдийн сүм, мамбын сүм, ядмын сүм, гүнрэг, за тэр даяндээрхийн хоёр орд байсан, диваажингийн дуган гээд арван дуган байсан юм.За энд тухай үеийнхээ лам нар хуваагдаж суугаад зориулалттай, зориулалттай тэр бурхан шашныхаа үйл ажиллагааг хийж, номоо хурж, ийм тогтмол ерөөсөө тэр хурал хурахгүй өдөр байхгүй.Бүгд одоо хурлаа хурж байсан.Тэгээд энэ цогчин сүм нь их том сүм байсан. Тэгээд нэгдсэн одоо тийм хурал хийхдээ тэр цогчин сүмдээ хийдэг. Наана тэр бусад сүмүүддээ дарь эхийн дуган, мамбын дуган гэхэд чинь одоо тэр чиглэлийнхээ хурал номоор тэр лам нар нь тасраад л хурдаг.Ингэж л хурлаа хурж байсан юм.За тэгээд яахав, эндээсээ лам нар элсээд л тэр хүүхдүүд лам болоод л , тэгээд энэ хүрээ хийддээ эндээ заагаад л , ном сургаад л тэр залуу лам нар чинь энэ тэндээс ч ирсэн юм биш, энэ орон нутгаасаа тэр олон лам нартай болж ирж байгаад л .Тэгээд л энэ төрт ёс айхтар болоод л , ер нь шашны үйл ажиллагаа сулраад л ирэхлээр зэрэг, хавчигдаад ирэхлээр зэрэг, за энэ ерөөсөө төр ч нэг л эвгүй болоод явчихлаа даа, за тэгэхээр залуу лам нар, энэ хүүхдүүдээ заавал ингэж байлгаад яахав, эднийг ерөөсөө хар болгоод хөдөө гаргачихая гээд л тэгээд л сангийнхаа мал хөрөнгийг тоолж бүх лам нартаа хуваагаад л тэгээд л оногдсон малыг нь тэд нартаа өгөөд л.За та нар ерөөсөө энэ манай данснаас, хүрээнээс хасагдлаа.Одоо та нар хар улс, өөрсдөө одоо амь тэжээж яв, энүүгээрээ. За энэ бурхан шашнаа бол яахав боддог санадаг тэр чигээрээ л байх хэрэгтэй.Энийг болвол алдаж болохгүй гэж ингээд л тараасан.

Мөнхбат: Жас гэснээс жас ер нь хэр баян зузаан жастай байсан юм бол?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Рагчаа: Жас уу, өө ярихгүй. Тэр болвол ерөөсөө хэмжээ хязгааргүй их малтай байсан. Тэр хэд ч байсан юм мэдэхгүй. Лав л энэ доод талд одоо найман зуугаад адуу, нэг суурь. Хоёр гурван суурьт одоо багтаачихсан байсан. Энэ хонин суурь бол энд тэндгүй зөндөө, үхэр болвол зөндөө байсан. Тэгээд ер нь тэр, би боддог юм. Тэр мянга шахуу ламд хуваахад гурав дөрвөн тугалтай үнээ нэг ламд оногдож байсан байх. Тэгээд арваад шиг ийм бод өгөөд, тэгээд цөөн бас нарийн мал өгөөд ингээд л хувь өгөөд л гаргаж байсан юм.

Мөнхбат: Одоо энэ бол хүрээ хийд хаагдахын өмнөхөн үе ш дээ, тийм ээ?

Рагчаа: Тийм.

Мөнхбат: Тэгэхээр энэ түрүүн бид ярилцлагынхаа эхэнд тэмдэглэсэн. Энэ хавийн одоо энэ бүс нутгийн, одоо энэ Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган, Цагаан-Үүр сум за Чандмань-Өндөр, Арбулаг, Тариалан сум энэ хавийг хамарсан одоо зүүн талыг хамарсан том бүс нутгийн одоо мөргөл шашны том төв байжээ гэж. Тэгэхээр энэ Дархинтын хурал, Уйлганы хурал, Цагааны хурал гээд Арханы хурал гээд энэ хурлууд бүгд үндсэндээ одоо Даяндээрхийн салбар цагийн хурлууд байж, тийм ээ. Одоо салбарлаж гарсан ийм хурлууд байж. Тэрнээс гадна энэ Буриадын буддын шашны түүхэнд энэ Даяндээрхийн хүрээ бол Буриадын шашин номын төв болж байсан Санагын хүрээтэй бас одоо их харилцаатай ажиллаж байсан гэж ингэж бас түүхэнд тэмдэглэсэн байдаг юм. Тэгэхээр одоо энэ талаар та бас санаж байгаа юм байна уу, жишээлбэл одоо ингэж тэмдэглэсэн байгаа юм. 1929 оны орчим юм шиг байгаа юм. Гол цогчин дуганд ямар нэгэн байдлаар гал гарч, тэнд. Тэгээд шатаж, тэгээд тэр жилдээ багтаагаад хүрээний урчууд нутгийн мужаан хар хүмүүс хамтраад тэр жилдээ багтаагаад одоо цогчин дуганаа сэргээгээд барихад Буриадын Санагын дацангаас таван зуун ширхэг гөлмөн төмрийг одоо шилжүүлж үнэ төлбөргүй өгч, тэр шинээр баригдсан цогчин дуганы дээврийг хийж байсан гэж одоо түүхэн баримт бас байдаг юм байна лээ. Тэгэхээр өнөөдөр одоо хилийн цаана байгаа Буриадын шашин номын төв, Санагын дацан гэж тэр хүрээтэй энэ Дээрхийн хүрээ бас эртнээс уламжлалтай холбоотой ингэж ажиллаж байсан юм болов уу?

Рагчаа: Энэ холбоотой байсан гэдэг юм аа. Одоо тэр цамын хэрэглэл жигтэйхэн гоё, жигтэйхэн одоо сайхан юмнууд байсан. Тэрийг Санагын хүрээнээс энд тавьсан юм гэнэ лээ. Тэрүүгээрээ тэр цам дэглэж, цам өгч гэлүү тэр Агийн хийдээс зурхайч нар ирж энд зурхай зааж байсан ийм түүхтэй юм. Тэгээд сүүлд нь тэр цамын хэрэглэлүүдийг чинь энэ боомтоор Ханхаар гаргаад буцаагаад явуулчихсан.

Мөнхбат: Буриад руу нь?

Рагчаа: Тийм. Тэр тэр л орон нутагтаа очсон байх учиртай. Тэгээд тэр Санагын хийдээс чинь одоо энд туслалцаа үзүүлж байсан гэдэг юм аа.

Мөнхбат: Энэ бурхан шашнаа одоо хяхаж, хавчиж лам нараа баривчилж шашин сүм хийдээ шатааж эхэлсэн тэртээ гучин долоо, гучин найман оны үед энэ Даяндээрхийн хүрээ ямар байдлаар хаагдсан бол, эхлээд лам нар нь хар болоод хаагдаад хүрээ эзгүйрчихээд хэсэг байсан уу, эсвэл шууд лам нарыгаа одоо барьж хорихыг нь хорьж устгахыг нь устгаад хар болгохыг нь одоо хүчээр хар болгочихоод тэгэнгүүтээ шууд энэ сүм дуганыг галдан шатаасан юм болов уу, энэ талаар одоо ямар түүх байна?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Рагчаа: Өө энэ болвол ерөөсөө тусгай хэлтсээс хүрч ирээд л эндээ одоо яахав, тэр ахмад лам нар чинь эндээ суусан чигээрээ л тэр хурал номоо хураад л байж байсан. Тэр үед л дөрвөн тэргүүн ламыг нь 1937 оны 12 сард л барьж аваад л...

Мөнхбат: Өвөл?

Рагчаа: Тийм өвөл ингээд явсан юм. За тэгээд л мөн өнөөдүүл чинь байсаар байсаар л байж байсан чинь...

Мөнхбат: Үлдсэн одоо лам нар нь?

Рагчаа: Тийм. Хурал номоо хураад л одоо эндээ л эргэлдээд л байж байсан. Тэр залуу лам нараа бол ерөөсөө тэр барихаас өмнө тэр ерөөсөө шашны үйл ажиллагаа жаахан шахагдаад хавчигдаад ирэхлээр зэрэг цаг үе ер нь шал өөр боллоо, одоо яахав энэ залуу хүүхдүүдийг энд ингэж байлгаж байж яахав гээд тэгээд халсан юм л даа. Халаад л яахав өв хөрнгийг нь өгөөд гаргачихсан. Тэгээд тэр лам нар чинь энийг чинь болвол шууд тусгай хэлтсээс хүн хүрч ирээд л ерөөсөө зүгээр шууд бариад л , тэгээд л тэр орон хашаа байшин юуг нь аваачиж лацдаж цаас нааж...

Мөнхбат: Битүүмжлээд л?

Рагчаа: Битүүмжлээд, тэр дуган энэ тэрийг нь ерөөсөө хуу хаачихсан. Тэгээд л энд ганцхан баригдаагүй үлдсэн Ренчиндорж гэж нэг өвгөн лам л үлдсэн байсан юм. За тэгээд л гучин найман оны зургаа долоон сард л, зургаан сар юм даа. Зургаан сард л тусгай хэлтсээс улсууд хүрч ирээд л нөгөө битүүмжилсэн юмнуудаа тэр айлын хашаа байшин тэр бүхнийг чинь онгойлгоод л доторх юмнуудыг нь одоо үздэг хардаг, авдаг юмнууд юу байсан юм. Одоо буу шийдэм байсан бол хурааж байсан байх. Тэгээд л ер нь голцуу тэгээд л дор нь тооллогодож үнэ зохиогоод л тэгээд л худалдаад л за тэгээд л энэ дуган сүмийг чинь тэгээд л орхиод явчихсан. Аа тэгээд л энэ болвол яасан бэ гэхлээр зэрэг энэ Цагаан-Үүр лүү зэгсэн их зөөсөн, дандаа энэ чинь өнгөн модоор барьсан дуган сүм юмнуудыг ийшээ энэ чинь сумуудын сургууль скалад янз бүрийн юманд их ашигласан. Тэгээд яахав дээ, эзэнгүй хаягдчихсан юм чинь. Аа тэгээд орон сууцны байшин майшин одоо юмнууд нь одоо ийшээ ингээд айлуудаар тараад л . Ийшээ энэ усаар уруудаад одоо Архан Буурал хүртэл одоо зөөвөрлөөд л, ингээд л тэгээд одоо энийг чинь яахав дээ, тэгээд дуусчихаж байгаа юм. Тэгээд л дуусгасан юм байгаа юм. Энд үлдсэн юмнуудаас байхгүй л дээ. Тэгээд Дээрхийн хөрөг гээд нэг тэр анхан Даяндээрх Чингистэй тулалдаж энэ дотор хувилсан чулуун хөрөг байсан. За тэрийг нь энэ аймгийн музейд аваачина гээд энэ Хөвсгөл аймаг руу ачиж аваачаад тэгээд аваачсан чинь тавьсан ч юм байхгүй. Тэр Бүрэнхааны ууланд тэгээд утгагүй ийм чулуу энд байгаад ч яахав дээ гэж бодсон юм байгаа биз. Тэнд гаргаад залчихсан л юм гэдэг юм. Аа тэгээд л ерөөсөө үлдсэн юм тэр, ерөөсөө л бүтэн үлдсэн юм тэр. Тэгээд бусдыг нь бол тэр энэ цац мац янз бүрийн баримал бүрхнүүд тэр бүх юмыг чинь энэ овооны цаадах жалганд аваачаад, өчнөөн тэргээр ачиж аваачаад тэгээд л асаачихсан юм.

Мөнхбат: Шатаагаад л устгачихсан?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Рагчаа: Тийм, тэгээд л одоо, тэгээд л одоо яахав дээ. Тэгээд л дуусчихаж байгаа юм. Тэгээд энүүгээр чинь тэр тооллогодож байх үед чинь өнөө нэг лам нарын гэрт байсан ном судар, бүх юмыг чинь зүгээр энд тэндгүй тараагаад л , энэ салхинд хийсээд л одоо бүр ерөөсөө замбараа цадиггүй дан цаас, ном.

Мөнхбат: Ингээд л одоо тэр олон жилийн түүхтэй бурхан шашны томоохон их хөлгөн судрууд, эрдэмтэн мэргэдийн одоо лам нарын их бүтээл, зөвхөн лам нарын бүтээл төдийгүй тэр чинь монголын ард түмний олон зуун жилийн соёлын маш том өв байж дээ, тийм ээ. Тэгээд л ингээд л хоромхон зуур байхгүй болохыг харахад бас одоо хэцүү л...

Рагчаа: Яриангүй, тэр чинь...

Мөнхбат: За ингээд үнэхээр одоо 1930-аад оны дунд үеэс эхэлсэн монголын буддын соёлын их өвийг устгах тэр хар бараан жилүүд энэ Даяндээрхийн хүрээг, хүрээний лам нарыг зүгээр хүрээг тойрон шүтэж байсан сүсэгтэн олныг одоо тойроогүй дайрч гарсан түүх бас энд одоо давтагдсан байх юм аа. За ингээд Даяндээрхийн хүрээний тухай бид нарт товч бөгөөд тодорхой мэдээллийг өгсөн энэ хүрээний сүүлчийн цөөхөн үлдсэн унаган шавь нарын нэг гэж хэлж болох Рагчаа гуайдаа баярлалаа. Таньд ингээд урт удаан наслахыг эрүүл энх байж энэ одоо хүрээ хийдийнхээ түүрийг сахиж Даяндээрхийн хүрээний үргэлжлэл болсон энэ өнөөдрийн энэ сэргэн мандаж байгаа бурхан номын үйл ажиллагаа сүсэгтэн олондоо үйлчлэх энэ их ариун үйлсэд чинь улам улам их амжилтыг хүсье. Ингээд энэ ярилцлагаа дуусгая.

Мөнхбат : За тэгэхээр манай судалгааны баг судалгааны ажлаа үргэлжлүүлээд энэ Даяндээрхийн хүрээний тууриас чанх хойшоо Дээрхийн уулын хавцлыг өгсөөд нэг арван долоон км явж байж хүрэх монголын алдарт домогт түүхтэй агуйнуудын нэг болох Даяндээрхийн агуйн амны яг урд талын, урд талд энэ агуйн амнаас зуугаад метрийн зайд байрлах Дээрхийн хурлын хоёр дуганы туурийн судалгааны ажлыг үргэлжүүлж байна. Тэгэхээр академич Ренчин гуайн монголын буддын шашны хүрээ хийдийн жагсаалт судалгааны зуудугаарт бичигдсэн энэ Дээрхийн хурал хэмээх шашин номын газар уг хоёр дуганд одоо үйл ажилаагаа явуулж байсан бололтой. Тэгэхээр энэ Дээрхийн хурлын тухай энэ хоёр дуганы үүх түүхийн тухай, ер нь яагаад Дээрхийн хурал ямар зорилгоор энд Даяндээрхийн хүрээнээс салбарлаж байсан тухай ярилцахаар мөн одоо тус сумын өндөр настан Рагчаа гуайтай бид нар ярилцлагаа үргэлжлүүлж байна аа. Тэгэхээр Рагчаа гуай, та энэ Дээрхийн хурлын тухай одоо бидэнд өөрт байгаа мэдээллээ хувалцана уу?

Рагчаа: За энэ яахав дээ, Даяндээрхийн агуй Даяндээрхийн өөрийн нь одоо энд хүрч ирсэн оромж байр нь бол энэ агуйд байсан байна аа гэж улсууд мэдэгдсэн түүхтэй. Тэгээд Даяндээрхийн ууган, энд одоо ирсэн өргөө байр нь бол ийм байдаг юм байна гээд л Даяндээрхийг энэ агуйд энд л оршиж байгаа гэж ингэж үзээд л тэгээд л ерөөсөө энэ Даяндээрхийгээ тахиж л тэнд ийм тахилга явуулж байсан. Өөр одоо тийм хурал ном хүрж байгаагүй л дээ. Ерөөсөө Дээрхийг л тахидаг. Дээрхээ л тахидаг, агуйгаа л тахидаг ийм байсан юм.

Мөнхбат: Энэ байнгын үйл ажиллагаа явуулж байсан юм болов уу, түр цагийн шинжтэй хурал явуулж байсан юм болов уу?

Рагчаа: Үгүй ээ үгүй. Түр цагийн, цагийн хурал л хийдэг.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Мөнхбат: Үе үе гарч л одоо?

Рагчаа: Тийм.

Мөнхбат: Энэ хүрээнээс лам нар гарч?

Рагчаа: Тийм ээ, эндээсээ лам нар очоод л агуйгаа тахина гэж. Агуйгаа тахидаг нэртэй байсан. Агуй тахина гэдэг маань Дээрхээ л тахиж байгаа юм.Тэр тахилгаар л тахиад...

Мөнхбат: Агуйн эзэн бол Дээрх?

Рагчаа: Тийм.

Мөнхбат: Тэгэхээр энэ хоёр дуган ер нь ямархуу хэмжээтэй дуган байсан юм бол оо, та энийг яг одоо бага байхдаа нүдээрээ харж байв уу?

Рагчаа: Би өөрөө харсан. За ер нь жижигхэн дээ. Нэг арван, за ер нь нэг талбай чинь одоо долоо наймын харьцааны л болов уу гэлтэй нэг тийм хоёр жижигхэн дуган байсан юм.

Мөнхбат: Модон дуган?

Рагчаа: Тийм, модон дуган.

Мөнхбат: Чулуун суурьтай юу?

Рагчаа: Тийм, чулуун суурьтай. Аа тэгээд суваргатай тэндээ, тийм суварга байсан юм. Ийм л юм байсан юм байгаа юм.

Мөнхбат: Энэ хоёр дуган бас л энэ Дээрхийн хүрээний сүм дуганыг одоо зөөж буулгаж нураах үед одоо давхар нураагдаад явсан уу, эсвэл бас дараа нь арай хожуу, хожим нь үлдсэн байсан юм байдаг юм болов уу?

Рагчаа: Хожуу үлдээгүй ээ.Яг энэ сүм дуганыг одоо бүүхад л тэр дотор чинь бас бурхан шүтээн янз бүрийн юмнууд байсан.Тэгээд тэднийг нь эвдэж устгаад л. Тэр ч байтугай тэр агуй дотроо байсан, тэр модон хөрөгтэй Даяндээрх байсан. Тэрний энэ талын баруун талын мутар энэ тэрийг нь хуга цохиод тэгээд тэр устгаж л байгаа нь тэр юм даа.Тэгээд л тэр л дайралтын үеэр нэг мөсөн л одоо гээд дуусгасан юм. Аа харин Уйлганы дуган ч гэлээ одоо тэр бас л доторхыг нь аваад л тэр гучин найман онд юу ч байхгүй хоосон дуган. Мал ахуйд хэрэглээд л ингээд л байж байсан. Архны дуган ч мөн адилхан.Тэр дуганыг чинь ерөөсөө тэр үед л тэр дуган сүм байгаа газруудыг чинь хэсж яваад л ингээд л буулгачихсан юм.

Мөнхбат: Тэгэхээр та түрүүн Даяндээрхийн хүрээний үүх түүхийг ярьж байхдаа цухас дурдаж байсан.Даяндээрхийн чулуун хөрөг гэж тийм ээ?

Рагчаа: Тийм.Тэгэхээр Даяндээрхийн чулуун хөрөг яг энэ агуйнхаа орчимд байсан юм уу, энэ хоёр дуганд байсан эсвэл тэр хүрээн дээрээ байсан юм болов уу. Тэр Хөвсгөл руу музей руу авж явж байгаа нэртэй тэр чулуун хөрөг хаана залагдаж байсан юм бол?

Мөнхбат:Тэнд байсан тийм ургаа чулуу байсан гэдэг юм.Энэ замын хажууханд, энэ замын хойд талд.Тэгээд Чингис, Даяндээрх хоёр чинь энд тулалдаад Даяндээрхийг чинь дарах гэж наашаа энэ лүү хүрч ирээд тэгээд энд энэ чулууны хажууд хүрч ирж гүйцэгдэж тэгээд энд тэр Дээрхийнхээ тэнд чулуунд хувилчихсан. Аа тэгэхлээр нь зэрэг Чингис аа чи эхлээд намайг нэг дийлсэн боллоо.Одоо би чамайг дийллээ. Аа чи одоо нэлээн зоригтой эр

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

юм байна. Аа чи тэгээд хувилгаан биендээ гар, хоёулаа ярьж гэж.Тэгээд гаргаж ирээд тэр наадах нь хувилгаан биендээ ч ороод ингээд тэгээд нэг ёсондоо хөрөг болоод л хоцорсон байгаа юм даа. Тэгээд энэ Сэлэнгийн ард талыг инч тасалж өгөөд ингээд одоо ажлаа хүлээлцээд ингээд яасан. Тийм чулуу эндээ уг л байнга л байсан чулуу.Тэгээд энд байна гэдгийг сүүлд, тэр Даяндээрхийг энд байгааг чиг сайн одоо сайн мэддэггүй л байсан юм байгаа биз.Нэг хонинд явж байсан хүүхэд уурга шилбүүрээр ороолгочихсон тэр нь авагдахаа байчихсан. За даа энэ чинь яагаад ингэчихэв, энэ ямар учиртай юм гэсэн. Тэгсэн тэр түүхийг нь сөхөөд үзэхлээр зэрэг Даяндээрх энүүнд хувилж байсан. Даяндээрх одоо энд байгаа юм байна гэж ингэж үзээд л.Тэгээд л Даяндээрх гээд тэр чулуугаа дуган сүм бариад тойруулаад тэгээд юу яасан, тахиж эхэлсэн.

Мөнхбат: Тахиж эхэлсэн?

Рагчаа: Тийм. Даяндээрхийг чинь уг нь Чингисийн цэрэг болгож Төвдийн далай лам нааш нь зарлиг гаргаж Ар монголд тэр бөөгийн шашны газар оч чи энд таарахгүй хүн байна гээд нааш нь явуулсан тэгээд бас энд шарын шашинтай сөргөлдөх одоо шарын шашинд дургүй болохлээр чинь Чингис хаан Төвдийн далай ламд зар хэл илгээж явуулж энэ Даяндээрх бол бүтэхгүй байна гэсэн тэгэхлээр зэрэг найман гэлэн явуулж бурхан сахил өг тэрүүнд гээд тэгээд бурхны сахилтай болсон. Тэгээд би нэг бурхны тахил авлаа гэдэг.Бөөгөө ч тахидаг, хоёр шүтээнтэй. Ийм л хоёр...

Мөнхбат: Тэгэхээр энэ Даяндээрхийн хүрээний тухай нэмэлт тэмдэглэл энд тайлбарлан хэлүүж тодотгох хоёр зүйлийг тодотгож энэ ярианы бичлэгт оруулъя. Тэгэхээр 1937, 1938 оны үед ялангуяа гучин найман оны эхээр Даяндээрхийн хүрээний сүм хийд дуган дацангуудыг, зөөж буулгаж нурааж байх үед үлдсэн одоо уран чамин хийцтэй, дорно дахины буддын уран барилгын хийц загвараар барьсан, тухайн үед энэ сүм хийд дуган дацангууд их уран гоё хийгдэж, ганц ч одоо хадаас оруулахгүйгээр углуургадан зангидаж, дорно дахины арга барилаар барьсан нэгэн одоо байгууламж байсан нь тухайн үед одоо Дээрхийн хүрээний хамба нарын орон сууц байсан гэж ингэж одоо хууччуул ярьдаг юм байна.Тэгэхээр тэр орон сууцыг энэ хүрээний сүүлчийн унаган шавь эдүгээ бид нартай ярилцлага хийж энэ ярилцлагыг манай багт өгч байгаа Рагчаа гуай одоо залуу насандаа тэрийг эвдэлгүйгээр нураалгүйгээр яг одоо тэрийг углаа, заадас, углуургаар нь буулган авч тэгээд Үүр голын тэртээ гаргаж өөрийн зуслан болох Эрдэнэбулган сумын төвөөс дөчин таван км-ын зайд байх ямар нэртэй газар билээ?

Рагчаа: Тарвагатайн булан.

Мөнхбат: Тарвагатайн булан хэмээх өөрийн зусландаа аваачиж барьжээ. Энэ лав одоо бид нарын тооцоогоор тавь гаруй жилийн, жараад жилийн тэртээ ийм одоо үед хамаарагдах юм байна.Тэгэхээр Рагчаа гуайн ярьж байгаагаар тэр одоо зөөж аваачсан хамба нарын сууцаа бол одоо болтол одоо яг хуучин будгаар нь дахиж будаагүй, яг тэр анхны барьсан бариастай байсан хэв загвараар нь одоо нэг ч хадаас оруулалгүйгээр ингэж барьсан. Зөвхөн одоо өмхөрч муудсан байсан банзнаас нь хоёр банзыг шинэчилж сольсон гэж ийм хуучийг бидэнд өгүүлсэн юм аа.Тэгэхээр одоо үндсэндээ Даяндээрхийн хүрээний тэр том хүрээ байсан, тэр олон сүм дуган дацан бүхий энэ хүрээнээс үлдсэн, бүрэн бүтэн үлдсэн ганц байшин бол өнөөдөр одоо Рагчаа гуайн

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

эзэмшилд ингээд Рагчаа гуай энийгээ хадгалж өөрийнхөө одоо гал голомтыг асааж зуслан байшин болгож ашиглаж байгаа юм байна гэдгийг энд хэлэхэд бас сонирхолтой юм. За нөгөө талаар Рагчаа гуайд мөн энэ Даяндээрхийн хүрээний одоо эрдэмтэй мэргэн лам нарынх нь нэг болох өөрийнх нь хадаг өргөж шавь орсон багш хүрээний аграмба цолтой Хариг хэмээх энэ багшийнх нь одоо үе дамжиж барьж байсан одоо халтар манан хөөрөг, шүрэн толгойтой халтар манан хөөргийг одоо бас энэ нутгийн хүн ямар нэгэн байдлаар тэр багшаас нь дамжуулан авч байсныг өөрөө бас нэлээн хэдэн жилийн өмнө худалдаж аваад одоо ингээд өөрөө барьж байгаа нь бас их сонирхолтой юм.Тэгэхээр үндсэндээ Даяндээрхийн хүрээний лам нарын одоо хүрээ хийдийн түүх соёлын дурсгалаас лавтай өнөөдөр манай судалгааны багт мэдээллэснээр ингэж тэр хамба нарынх нь сууц, тэр том аграмба багшийнх нь барьж байсан хөөрөг хоёр нь энэ Рагчаа гуайд өвлөгдөн үлджээ.